

Манмин Мэдээ

№ 33 2013 он 4-р сарын 7

“Тэнгэр орон мэт аз жаргал дүүрэн Эзэний өдөр” жинхэнэ амралт болон сүнслэг баяр хөөрийг эдэлдэг манай сүмийн итгэгчид.



1. Ням гаригийн Өглөөний Хүндэтгэлийн их мөргөл (Төв танхимийн байдал) 2. Нисси Оркестра болон Ариун хоор дуу 3. Ням гаригийн Үдээс хойшхи мөргөлийн өмнөх магтан дууны бэлтгэл 4. Цагаан Чулуу ариун хоор дууны онцгой үзүүлбэр 5. Шинээр ирсэн хүмүүсийн өдрийн хоол 6. Эсийн бүлгийн цугларалт 7. Манмины сайн дурынхны бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тэргэнцэрийн тусламж

Энэ ертөнцөд хичнээн нэр алдар, эд баялаг, аз жаргалыг эдлэлээ гээд Эзэний өдрийг төгс сахисанаар дамжуулан энэ бүгдтэй зүйрлэшгүй жинхэнэ амар тайван болон ивээл ерөөлийг олж авдаг.

“Эзэний өдрийг сахина” гэдэг нь Бурханы агуу их сүнслэг эрх мэдлийг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг юм. Эзэний өдрийг ариунаар сахих үед Бурхан бидний асуудлыг зохицуулан шийдэж өгч, бидний сүнс сэтгэлийг сайжруулж, сүнсээр өсөхөд туслан, түүнчлэн бүхий л зүйлийг сайн амжилттай болгож, эрүүл энх болон ерөөлийг ч өгдөг. Бид Эзэний өдрийг төгс сахивал Бурхан бидний сүнсний өсөлт, эрүүл мэнд, үр хүүхдүүд, ажлын газар гэх мэт бүхий л зүйлстэй хамт байж, хамгаалж өгөх тул бид бие ба сэтгэлээрээ жинхэнэ амралт, аз жаргалыг эдэлж, тохиолдож болзошгүй бүх төрлийн осол аваар, өвчин, сорилт, гай зовлонгоос долоо хоногын турш хамгаалагдах ерөөл хүртдэг билээ. (Исаиа 58:13-14)

Манмин бүх итгэгчид 10,000 гаруй салбар сүм болон хамтран ажилладаг сүмийн бүх итгэгчид нь Ням гаригийн өглөөний мөргөлийг Төв сүмд Ням гаригийн өглөөний мөргөл орон нутгийн цагаар Солонгост 10 цагт 1-р Хүндэтгэлийн их мөргөл, 2-р Хүндэтгэлийн их мөргөл 11.30-д (GCN) Жи Си Эн телевиз, интернетээр дамжуулан И Жей руг Тэргүүн пасторын сургаалийг шууд хүлээн авдаг билээ.

Үй олон удаагийн мацаг барилт болон залбирлуудаар дамжуулан Бурханаас тайлж өгсөн И Жей руг пасторын сургаалуудын гол утга санаа нь Бурханы хүсэл, сэтгэлийг яг нарийн илэрхийлж өгдөгөөрөө онцлогтой. Яг одоо Тэргүүн пастор маань “Итгэлийг хэмжих нь”, “1 Иохан тайлбар” гэсэн цуврал

сургаалууд төдийгүй түүний бусад сургаалууд нь итгэлийн анхан шатуудыг өнгөрч “итгэлийн хадан суурь” болон сүнс рүү цаашлаад төгс сүнс рүү орох арга замыг зааж өгдөг ба мөн өөрсдийн амьдралдаа Бурханы үгийг хэрэгжүүлэн, ивээл ерөөлийг хэрхэн яаж авах, Бурханы гайхамшигт ерөөлөөр бялхам дүүрсэн итгэгчид болох арга замыг зааж өгдөг.

Түүнчлэн ариухан үр хүүхэд болохыг хүсэж буй Бурханы хүслийг мэдэх учир гэм нүглийн тухай анхааруулан сургаж буй байдлыг ч түүний сургаалийн чухал хэсэг яахийн аргагүй мөн билээ. Итгэгчид энэ мэт сүнс, сэтгэл болон үе мөч, нугас чөмгийг салтал нэвтрэн орох сургаалиар дамжуулан Бурханы гүн гүнзгий хайрыг мэдэрч, өөрсдийгөө өөрчлөн, Тэнгэрийн орны хүсэл найдвараар дүүрэн болдог.

Ням гаригийн Өглөөний Мөргөлийн дараа итгэгчдийг итгэлээр өсгөж, халамжлах нөхөрлөлийн цаг байдаг. Эрэгтэйчүүдийн баг, эмэгтэйчүүдийн баг, Канаан баг, Залуучуудын болон Гадаадын итгэгчдийн баг, Хятад итгэгчдийн баг, хэлгүй болон харааны бэрхшээлтэй итгэгчдийн баг, Эзэний хайр баг (Хойд Солонгосын цагаач иргэд) гэсэн багууд тус тусдаа өөрсдийн уулзах газартаа цуглаад өдрийн хоол идэж, итгэлээр өсөхөд нь дэмжин туслаж, нөхөрлөдөг.

Ням гаригийн үдээс хойшхи мөргөл 15 цагт эхлэхээс өмнө итгэгчид магтан дуугаар өөрсдийнхөө зүрх сэтгэлээ нээлттэй болгон, ивээл авахыг хүсэн тэмүүлж, мөргөлдөө бэлддэг. Мөргөлд Нисси Оркестра хөгжмийн багтай ариун хоор дууны баг магтан дуу өргөдөг. Мөн түүнчлэн магтан дуу, орчин үеийн болон уламжлалт бүжиг, хүндэтгэлийн бүжиг, төрөл бүрийн хөгжмийн үзүүлбэрүүд, Солонгосын сонгодог

алдартай хөгжим, балет гэх мэтчилэн олон төрлийн онцгой урлагын тоглолт үзүүлбэрүүд тоглодог. Эдгээр тоглолтуудыг итгэгчид үзсэнээр зүрх сэтгэл нь илүү нээлттэй болж, Бурханы үгийг баяр хөөртэйгээр хүлээн авдаг юм. Энэ сайхан магтаалын тоглолтуудаар дамжуулан мөргөл илүү их ивээл ерөөлөөр дүүрч, итгэгчид Бурханд бүх алдар магтаалыг өргөж байдаг.

Манай сүм нь магтан дууны Нисси мэргэшсэн Оркестра болон хоор дууны 5 баг, 25 урлагын баг, 20 гоцлон дуучидтай ба төрөл бүрийн мөргөл цуглаануудад Бурханы баярлан таалах магтаал ба тоглолтыг хийхийн төлөө хичээн зүтгэдэг.

Ням гаригийн Өглөөний болон үдээс хойшхи мөргөлүүд нь Солонгост болон бусад орнуудад байдаг гадаадын итгэгчидэдээ зориулан Англи, Орос, Испани, Франц, Япон, Монгол гэсэн долоон хэлээр нэгэн зэрэг орчуулагдаж байна. Мөн хэлгүй болон сонсголын бэрхшээлтэй хүмүүст зориулан дохионы хэлээр мөргөлөө явуулдаг.

Мөн түүнчлэн Манмин Төв Сүмийн И Жей руг Тэргүүн пасторын залбирлаар тоолж баршгүй олон гайхамшигт ажлыг Бурханы хүч чадлаар хийсээр байгаа билээ. Зөвхөн хариулт авсан болон эдгэрсэн итгэгчдийн гэрчлэлийг л сонсоход итгэлээр хангалттай сайн өсөх ивээл ерөөл болж байна. Тэд Бурханы үгнээс юу олж мэдсэнээ хуваалцаж, бие биенийхээ төлөө зуучлан залбирлыг хийдэг. Энэ нь итгэгчдэд яг л гэр бүл шиг сүнслэг харилцаа холбоог мэдрүүлдэг юм.

Энэ мэт Бурханд Эзэний өдрийг ариунаар өргөсөнөөр Манмины итгэгчид Бурханы хамгаалалтанд амьдарч Түүний ивээлээр дүүрэн долоо хоногыг өнгөрүүлж чаддаг юм.

Хайр бол тэвчээртэй

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр агаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй” (1 Коринт 13:4).



Доктор И Жей руг Тэргүүн Пастор

Түргэн зантай хүн тэвчээргүйгээсээ болж маш их алдаа гаргадаг. Итгэлийн амьдралаар амьдардаг ч хүлээцтэй байж чадалгүй, яарсан үйлдэл хүмүүс ч байдаг. Жишээлбэл тэд гэм нүгэл, хорон муу зан чанараа хаяхын тулд гал халуун залбирч, мацаг барьсан ч тэдний бодож байсан хэмжээнд хүрэхгүй, бага зэргийн өөрчлөлт гарах үед тэд итгэл алдарч, зориг мохох мэдрэмж төрдөг байна. Мөн хариулт авахын төлөө чин сэтгэлээсээ өргөл бэлдэн өргөж, залбирсан ч ямар ч нөлөө байхгүй бол тавгүйтэж ивээлээр унадаг.

Энэ мэт залбирлын хариултаа авах нь мэдээж, 1 Коринт 13-р бүлэгт айлдсанчлан сүнслэг хайрыг олохын тулд бид тэвчээртэй байх хэрэгтэй ба ингэснээр бид үзэсгэлэнтэй сайхан үр жимс гаргаж чадна.

1. Тэвчээртэй хайр гэж юу вэ?

1 Коринт 13:4-өөс цаашаа үргэлжлүүлэн уншвал сүнслэг хайрын талаар 15 шинж чанарыг дурдсан байдаг. Хамгийн эхний шинж нь “Хайр бол тэвчээртэй” гэсэн байна. Үүний цаад сүнслэг утга нь яг юу юм бол? Энэ нь бид бүхэн ямар ч хэцүү, хүнд байдалд орсон өрөөл бусдын төлөө гэсэн сэтгэл өвөрлөж, бусдыг хайрлахыг хичээн зүтгэж, тэвчээртэй байж, сүнслэг хайраар тэвчиж өгөх шаардлагатай гэсэн үг юм.

Хэрэв хэн нэгэн хүн надад агаархаж, би ямар ч буруу зүйл үйлдээгүй байхад үзэн ядах тохиолдол байдаг. Таны эргэн тойронд магадгүй ийм хүн байдаг бол түүнээс хол байхыг, бүр санаандгүй байдлаар ч уулзах, тааралдахыг ч хүсэхгүй байж болох юм. Тийм бол Бурханы үгэнд “Дайснаа хүртэл хайрла” гэсэн үгийг сонсоод “Яаж би тэр хүнийг хайрлах билээ?” бодолхийлэн, санааширдаг. Гэвч сүнслэг хайрыг олсон бол ийм хүнийг ч гэсэн хайрладаг билээ. Хэн нэгэн хүн ямар ч шалтгаангүй таныг хэцүү байдалд оруулж, үзэн ядаж байсан ч та сэтгэлээ захирч, түүнийг өршөөн уучилж, тэвчин, хайрлах хэрэгтэй юм.

Энэ мэт Бурханы үгэнд дуулгавартай даган үйлдэх үед тохиолдох бүхий л хүнд хэцүү байдлыг тэвчинэ гэдэг нь тэвчээртэй хайр юм. Гэхдээ Хайрын бүлэгт тэмдэглэгдсэн “тэвчээр” нь Ариун Сүнсний есөн үр жимсэнд тэмдэглэгдсэн “тэвчээр”-тэй харьцуулбал утгын хувьд арай дутмаг шинж чанартай байдаг.

Ариун Сүнсний есөн үр жимсэнд тэмдэглэгдсэн “тэвчээр” нь Түүний зөвт шударга байдалд, Бурханы хаанчлалын төлөө ямар ч нөхцөл байдалд орсон бүх зүйлд тэвчээртэй байх хэрэгтэй гэсэн байдаг бол харин хайрын бүлэгт тэмдэглэгдсэн “тэвчээр” нь бусдыг хайрлах тэвчээрийн тухай айлдсан хувийн шинж чанартай зүйл юм.

2. Тэвчээртэй хайрын хүч чадал.

Матай 5:44-д “Харин Би та нарт хэлье. Дайснудаа хайрла, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” гэсэн байдаг. Энд ‘дайсан’ гэдэг нь өшөө хорсол төрүүлэхүйц хэмжээний хохирол учруулдаг хүнийг байгаа юм. Гэмт хүмүүсийн төлөө энэ газар дээр ирсэн Есүс дайснаа ч хайрлаж, Түүнийг хавчиж байсан хүмүүсийн төлөө залбирч байсан юм. Тэр хүмүүсийн төлөө зөвхөн сайн сайхныг л хийж байхад харин хүмүүс Түүнийг доромжилж, доог тохуу хийж, дорд үзэж байсан. Тэгсэн ч гэсэн Есүс “Аав аа, тэднийг уучлаач. Учир нь тэд юу хийж байгаагаа мэдэхгүй байна” (Лук 23:34) гэж Бурханд тэдний төлөө зуучлан залбирч байсан билээ.

Есүс Бурхантай дайсан болсон хүн төрөлхтөнийг удаан тэвчин, мөн хайрласан бөгөөд үүний үр дүнд Эзэнийг аврагч Эзэнээр итгэн, хүлээн авсан хүн болгон дайсан сатан, муу ёрын сүнсний боолчлолоос чөлөөлөгдөж, Бурханы хүүхэд болох гайхамшигтай авралын хүч нөлөөг хүлээн авдаг. Энэ мэт тэвчээртэй хайрын хүч чадал бол агуу юм.

Тэгвэл та хир зэрэг удаан тэвчээртэй байж чадах вэ? Ямар ч учир шалтгаангүйгээр таныг үзэн ядаж байгаа хүмүүсийг та тэвчээртэйгээр хайрлаж чадаж байна уу? Эсвэл, таны хувьд хэдийгээр дайсан биш бүр таны хамгийн ойр дотны чинь эхнэр эсвэл нөхөр тань, хүүхдүүд тань, эсвэл итгэлийн ахан дүүс нартаа ч гэсэн “тэсэхэд гэж хэцүү дээ” гэдэг үү?

Матай 5:39-40-д “Харин Би та нарт хэлье, хар санаатай хүнийг бүү эсэргүүц. Харин хэн баруун хацрыг чинь алгадна, түүнд нөгөө хацраа бас тавьж өг. Хэн нэгэн хүн чамтай заалдаж, цамцыг чинь авахыг хүсвэл дээлээ бас түүнд өг” гэж бичсэн байдаг. Хэн нэгний дотуур хувцсыг нь хүртэл авна гэдэг нь ямар ичгэвтэр хэрэг вэ! Энэ нь ийм нөхцөл байдалд ч гэсэн бүр

илүү их хайрла гэсэн үг юм.

Сүүлийн үед бусад хүн өөрийн амь бие эд хөрөнгөд өчүүхэн ч гэсэн хохирол учруулахад тэвчилгүйгээр заргалдах үе ч байдаг. Мөн энэ тохиолдол өөрийн эхнэр, нөхөр, эцэг эх, эсвэл хүүхдэд тохиолдсон ч мөн тэгж ханддаг. Тэгвэл бидэнд ийм явдал тохиолдвол дэлхийн хүнтэй адилхан хариуг нь өгөх хэрэгтэй юу? Үгүй биз дээ. Харин бид тэвчин, сайнаар хандах хэрэгтэй.

Зарим хүмүүс “Би тэгж хохирол амсаж, сэтгэл санааны дарамтанд орчихоод яаж тэвчиж чадах юм бэ” гэж хэлэх байх л даа. Гэхдээ бидэнд сүнслэг итгэл, сүнслэг хайр байсан цагт бид үүнийг хичнээн л бол хийж чадна. Яагаад гэвэл Тэрээр Өөрийн цорын ганц хүүг нь цовдолсон гэмтэнгүүдийг ч өршөөн уучилж, хайрласан Бурхан Аавын хайр ба итгэл бидэнд байгаа учраас юм.

Бурханаас бид ийм хайрыг нь хүлээн авсан гэдэгтээ итгэлтэй байвал танд хичнээн том хохирол учруулсан хүнийг уучилж чадах юм. Бидэнд өөрийн амь насаа харамгүйгээр өгсөн Их Эзэнийг хайрладаг бол хайрлаж чадахгүй ямар ч хүн байхгүй билээ.

3. Сүнслэг тэвчээрийг олж авахын тулд

Зарим хүмүүс үзэн ядалт, уур хилэн, тэвчихийн ч аргагүй догшин ааш авир гаргах үед, биеэ барих гэж их хүчилдэг боловч тэвчээр нь барагдах үед тэд тэсэрч дэлбэрдэг. Харин зарим хүмүүс бүрэг ичимхий дотогшоо зан чанартай учраас уурласан ч сэтгэлийн хөдөлгөөнөө гадагшаа илэрхийлж чаддаггүй байна.

Бурханы хүсэж буй тэвчээрийн сэтгэл нь хувирашгүй тэвчээрийн сэтгэл юм. Өөрөө хэлбэл, энэ тэвчээр гэдэг нь зүгээр л нэг “тэвчээр хатуужил” гэж амаараа тунхагласан үг байх хэрэггүй. Мөн энэ нь үзэн ядалт, гоморхол зэргийг сэтгэлдээ хураах бус энэ бүхнийг бий болгодог угийн атгаг байдлыг цэвэрлэн гаргаж, хайр ба өршөөл болгох нь жинхэнэ сүнс зүгийн тэвчээр билээ.

Сэтгэлдээ атгаг байдалгүй сүнслэг хайраар л дүүрэн байвал дайснаа хайрлана гэдэг тийм ч хэцүү зүйл биш юм. Тэгээд бусадтай ч дайсагнах явдал байхгүй болж, хичнээн ойлгомжгүй хүн байсан ч хайр хүрмээр харагдах болно. Алдаа дутагдал, болон сул тал ихтэй дургүйцдэггүй, намайг үзэн ядаж, дургүй байсан ч үзэн яддаггүй билээ.

Харин эсрэгээр бидний сэтгэлд үзэн ядалт, хэрүүл тэмцэл, хардалт, агаархал гэх мэт хорон муу зан чанар байвал хичнээн сайн хүн байсан ч миний сэтгэлд нийцэхгүй бол сул талыг харан дургүйлхэх байдал түрүүлж байдаг. Мөн өөрөө худлаа ярихдаа сайн бол бусад хүн хичнээн үнэнийг хэллээ ч худлаа ярьж байна л гэж бодох болно.

Тэгвэл бид хорон мууг үйлдэж буй хүнийг хэр зэрэг тэвчих хэрэгтэй вэ? Энэ тухай Петр ирж Есүст “Эээн, ах дүү нар маань миний эсрэг нүгэл үйлдэхэд би хэдэн удаа түүнийг уучлах вэ? Долоон удаа юу?” гэж асуудаг. Гэтэл нь Есүс айлдсан нь “Би чамд долоон удаа гэж хэлэхгүй. Харин дал дахин долоон удаа гэж хэлье” (Матай 18: 21-22).

Энд “долоо” гэдэг тоо нь төгс төгөлдөрийг билэгддэг учраас бүрмөсөн, төгс уучлах ёстой гэсэн утгатай юм. Энэ нь хэзээ ч дуусашгүй хайр ба уучлал юм. Мэдээж та өөрийн үзэн ядах, хорон муу чанараа шууд нэг өдрийн дотор хайраар өөрчлөнө гэдэг тийм амар хялбар зүйл биш л дээ. Гэвч зогсолтгүйгээр чармайн зүтгэх хэрэгтэй. Хүн тус бүрийн итгэлийн хэмжээнээс шалтгаалж тавгүйтэл юм уу, уурласан ч гэсэн үүнийг хаяхын төлөөх тасралтгүй хичээн зүтгэвэл бага багаар өөрчлөгдөж, сүнс зүгийн хайраар өсөж хөгжих болно.

Зүрх сэтгэлд гүн суугдсан гэмт зан чанарыг Ариун Сүнсний бялхам байдалд гал халуун залбирах үед хаягдах болно. Мөн та өрөөл бусдыг хайраар харж, сайнаар хандахыг хичээнгүйлэн мэрийж зүтгэх хэрэгтэй. Ингэж үйлдсээр байтал нэг л мэдэхэд таны сэтгэл дэх үзэн ядалт, агаархал, гомдол, хорон муу бүхэн алга болж, бусдыг хайрлах сэтгэл төрөх болно. Хэн нэгэнтэй тулж, мөргөлдөх сэтгэлгүй, танд үзэн ядах, агаархах, гомдох хүн байхгүй бол та яг л Тэнгэрийн оронд байгаа мэт ер бусын аз жаргал, амар тайван, баяр баясалыг мэдэрнэ. Тиймд бүхий л худал хуурмагийн шинж чанаруудыг хаяж, сайн ба хайраар дүүрэх тул тэвчээр ямар ч хэрэггүй болж харин үүний оронд бүгдийг халуунаар хайрлаж чаддаг болно.

Зүрх сэтгэлд хорон муу чанаргүй, сайхан сэтгэлтэй болох тусам тэвчээртэй байх, тэсэх, тэвчин өнгөрүүлэх гэсэн ойлголт байдаггүй болдог. Тэвчих шаардлагатай үед гарвал тэд тэвчээртэй байх гэж хичээх ч хэрэггүй харин цаад хүнээ өөрчлөлтөл хүлээх чадвартай болчихсон байдаг. Тэнгэрийн оронд тэвчээр хэрэгтэй гэж та бодож байна уу? Тэнгэрийн оронд зөвхөн сайхан сэтгэл хийгээд хайр л байдаг. Тэнд ямар ч нулимс, уй гашуу, өвчин зовлон, хорон муу юу ч байдаггүй. Мөн үзэн ядалт, уур уцаар, агаа жөтөө, хорсол зэвүүцэл ч байхгүй билээ. Харин Бурхан “хайр бол тэвчээртэй” гэж айлдсаны учир нь хүмүүсийг үүднээс ойлгуулахын тулд айлдсан үг юм.

Хайрт ах, эгч, дүү нараа, хорон муугын хэлбэрийг ч гэсэн тайлан хаяснаараа өөрөө болон ямар ч атгаг нэгэн байсан ч хайраар удаан тэвчин хүлээдэг болохыг Их Эзэнийхээ нэрээр хүсэн ерөөе!

Монгол Манмин Төв Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшх мөргөл	Ням гариг 13: 40
3-дахь өдрийн мөргөл	3 дахь өдөр 18: 00
5-дахь өдрийн мөргөл	5 дахь өдөр 22: 00
Хүүхдийн мөргөл	ням гариг 10: 30
Сурагч залуучуудын мөргөл	Хагас сайн өдөр 16: 30

Залбирлын цаг

Ангилал	Цаг	Удирдагч
Даниел үүрийн залбирал	Даваа- баасан 05: 00- 06: 00	Ш. Золзаяа (Том хүний баг хариуцагч)
Даниел өдрийн залбирал	Даваа- баасан 09: 00- 10: 00	П. Уртнасан (2Том хүний баг хариуцагч)
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18: 30- 20: 00	П. Батзориг (Чуулганы хариуцагч)



Хаяг: Баянзүрх дүүрэг, 13-р хороолол 6-р хороо, ой булан- 6 иргэний А.О.С
Утас: чуулганы- 5525-7637 чуулганы хариуцагч- П. Батзориг 9117-0773

www.manmin.org
www.manmintv.org



Миний сэтгэл ямар талбайтай адил вэ?

Есүс хүний зүрх сэтгэлийг нүдэнд харагдах хөрс шороо, талбайтай зүйрлэсэн билээ.

Үүнд Тэрээр зүрх сэтгэлийн тухай айлдахдаа бодитоор зам хавийн хөрс, хадтай чулуурхаг хөрс, өргөс болон хогийн ургамалтай хөрс, сайн хөрс гэсэн дөрвөн төрөлд хуваан тайлбарласан юм. Зүрх сэтгэлийн талбай нь ямар аав ээжээс төрсөнөөс шалтгаалан хүний зүрх сэтгэлийн талбай бүрэлдэн бий болж, ямар орчин нөхцөлд, юу сурч, өсөж хүмүүжив гэдгээс шалтгаалан хүний зүрх сэтгэлийн талбай (хөрс) өөрчлөгдөж, мөн хэлбэржин тогтох болдог.

Энэ мэт зүрх сэтгэлийн талбайн ялгаатай байдал нь хүн тус бүрийн амьдралд ч нөлөө үзүүлдэг. Ялангуяа итгэлийн амьдралд сүнсэлг өсөлтийн хурдацад мөн нөлөөлж, ялгаа гарах үе ч бий. Гэхдээ хамгийн чухал зүйл нь Бурханы хүч чадлаар л ямар ч төрлийн хөрсийг сайн хөрс болгож болох ба арвин их үр жимс хурааж авах баяр хөөрийг зүрх сэтгэлийн талбайгаа боловсруулах үеийн хичээл зүтгэлтэй харьцуулбал юу ч биш билээ. Эрхэм та ч гэсэн өөрийн зүрх сэтгэлийнхээ хөрсийг шалгаж мэдсэнээр хичээнгүйлэн хагалж боловсруулан, сайн болон үзэсгэлэнтэй гэрлийн үр жимсийг арвин ихээр гаргаасай гэж хүсэж байна.

Замын хавийн хөрс

“Түүнийг үрээ цацахад зарим үр нь замын хавиар унасанд шувууд ирээд идчихжээ” (Матай 13:4).

Тариачид үрээ цацах үед зарим үрнүүд замын хажуугаар унадаг. Тэр замын хажуугаар унасан үр нь хатуу газар унасан учир үндэслэж чаддаггүй. Тэр үр нь хөрсөнд булагдаагүй учраас огт нахиалах ч үндэслэх ч боломжгүй бөгөөд шувууд ирээд унасан үрнүүдийг идчихдэг.

Замын хавийн хөрс мэт хатуу зүрх сэтгэлийг илэрхийлдэг. Ийм зүрх сэтгэлтэй хүмүүс нь Бурханы үгийг ойлгодоггүй, сонссон ч итгэдэггүй зүрх сэтгэл юм. Ариун Сүнсний мэдрэмжгүйгээр сүмд зөвхөн ирж, очдог тохиолдолууд их байдаг. Ийм тохиолдолд

итгэлтэй болохын тулд илүү их хичээх хэрэгтэй бөгөөд ийм сэтгэлтэй хүмүүс өөрийгөө ийм дүр төрхийг заримдаа ухаарч чаддаггүй.

Энэ мэт зам хавийн хөрсийг хагалж боловсруулахын тулд бардам зан, зөрүүд, өөрийн бодол сана худал хуурмаг, заль мэх зэргийг хаяж, өөрт суулгагдсан хувийн бодол хийгээд өөрийгөө өргөмжлөх зэргийг хагалах ажиллагаа зайлшгүй шаардлагатай.

Удаан хугацааны турш худал хуурмаг ёс бус зүйлүүдээр хатуурсан сэтгэлийг дахин дахин хагалж буталмагцаа

үргэлжлүүлэн боловсруулах үйл ажиллагааг хийх ёстой байдаг.

Жишээлбэл хэрвээ сургаал нь таны өөрийн үзэл бодол, оюун санаатай нийцэхгүй тохиолдол болгонд “Миний үзэл бодол үнэхээр зөв үү?” гэж маш нухацгай эргэцүүлэн бодох шаардлагатай. Мөн Бурхан танд хайр ивээлээ өгөхийн тулд зарим нэгэн сайн зүйлсийг үргэжлүүлэн хийх хэрэгтэй юм. Ийм сэтгэлтэй хүн өөрчлөгдөхийн тулд өөрийн хичээл зүтгэл чухал ч гэсэн түүний гэр бүл, сүмийн удирдагч ахлагч нар тэдний төлөө залбирч, зааж сурган зөв замчилах нь хамгийн чухал юм.

Хад чулуурхаг газар

“Зарим нь чулуурхаг газар унаж, хөрс нь гүн биш тул тэр дороо соёолов. Гэвч нар гарахад үндэсгүй учир тэд хорчийн унажээ” (Матай 13:5-6).

Чулуурхаг газар гэдэг нь чулуутай холилдсон ба дээр нимгэмтэр хөрс шороогоор тохиолдол их байдаг. Иймэрхүү газрын хөрс шороо нь тийм ч гүн биш учраас унасан үр нь маш хурдан соёолох боловч тун удалгүй наранд хатаж хорчийдог байна.

Чулуурхаг хөрс бүхий сэтгэлтэй хүн нь сургаал үгийн үндэс нь зүрх сэтгэлд буй чулуунаас болоод үндэслэж чаддаггүй. Өөрөөр хэлбэл сургаал сонсоод баярлан ивээл авдаг ч ямар нэгэн шалгалт, сорилт, хавчлага ирэхэд чулуурхаг хөрстэй адил сэтгэлэй хүмүүс маш амархан унадаг. Ялангуяа, чулуурхаг хөрсний чулуу нь

“Дэлхийг зүйлийг хайрлах” сэтгэлийг илэрхийлж байдаг. Өөрөөр хэлбэл Бурханд итгэж Түүнийг хайрлаж чаддаггүй худал хуурмагийн сэтгэлийг нэрлэж болох юм. Гэхдээ адил чулуурхаг хөрс гээд энэ хорон муугийн чулуунууд хэр зэрэг том, гүн гүнзгий суулгагдсанаас шалтгаалан хоорондоо ялгаатай байж болно.

Мөн “үндэслэж чаддаггүй” гэдэг нь тэдэнд жинхэнэ итгэл, өөрөөр хэлбэл сүнсэлг итгэлтэй болж чадаагүй гэсэн үг юм. Хэдийгээр тэд Бурханы үгийн сонсоод ойлгосон л төдий бөгөөд тэд чин сэтгэлээсээ ухаараагүй, зүрх сэтгэлээрээ итгэж чадаагүй гэсэн үг юм. Ийм итгэлийг

“махан биеийн итгэл” буюу “мэдлэгийн итгэл” гэж нэрлэдэг.

Чулуурхаг хөрсийг боловсруулахын тулд Бурханы үгийн дагуу хичээнгүйлэн үйлдэж, чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй. Ариун Сүнсний бялхам байдлаа хадгалахийн тулд явцын дунд үед сэтгэлийн талбайгаа хагалах ажлаа зогсоож болохгүй. Мөн ивээл авсан сургаал болон Ариун Сүнсээр бялхах үед удирдаж буй дуу хоолойг сонсон дуулгавартай дагах хэрэгтэй. Бурханы хүч чадлаар гарцаагүй сайн хөрс мэт сэтгэлтэй болох боломжтой хэмээн итгэж, шантрашгүй, зүтгэж байж л хариулгаа авах болно.

Өргөс болон хогийн ургамалтай хөрс

“Зарим нь хогийн ургамлийн дунд унав. Хогийн ургамал ургаж тэднийг барьчихаж” (Матай 13:7).

Энд “өргөст бут” гэдэг нь бутлаг бөгөөд олон салаа мөчиртэй өргөстэй ургамлыг хэлж байгаа юм. Мөн хогийн ургамал, шарилж бүхий талбайг илэрхийлж байгаа юм. Ийм газарт унасан үр нь соёолж, тодорхой хэмжээнд ургадаг ч нөгөө өргөст ургамал ба хогийн ургамал нь тэднийг барьж, цаашид илүү сайн ургах нөхцөлгүй болж үр жимсээ өгч чаддаггүй юм.

Энэ төрлийн сэтгэлийн шинэ чанар нь зүрх сэтгэлд буй энэ дэлхийн элдэв зовиол, мөн эд хөрөнгө ба эрх мэдэл зэрэгт шунах сэтгэлийг хэлдэг. Ийм зүрх сэтгэлтэй хүмүүс Бурханы үгийн дагуу

амьдардаг гэсэн ч урьдын л адил сорилт, гай зовлон дотор амьдарсаар байдаг.

Энэ хогийн ургамалтай хөрс мэт сэтгэлийг боловсруулахын тулд эцэст нь хүртэл хорон муу, шуналын сэтгэлийг үндэсээр нь сугалан хаях хэрэгтэй. Тиймээс махан биеийн бодол санаа нь зүрх сэтгэлд буй атгаг байдлын улмаас бий болдог хорон муугийн үндэс мэт зүйл юм. Хичнээн ийм бодолд автахгүй байя гэсэн ч сэтгэлд хорон муу чанар байвал өөрийн хүссэний дагуу болж өгдөггүй билээ. Жишээгээр дурьдвал олон төрлийн үндэснүүд дундаас бид

бүхэн шунал болоод бардам зан, гэсэн хоёр үндэсийг л сугалан хаяж чадвал, зүрх сэтгэлээс дийлэнх нь дээрх хоёртой холбоотой хорон муугийн хэлбэрүүд хамтдаа хаягдах учир сэтгэл тэр хэмжээгээр цэвэршигдэх болдог.

Мөн Бурханы үгийг үргэлж бодон, тунгаан бясалгаж, тасралтгүй залбирч, Ариун Сүнсний тусламжтайгаар маш амархан хорон муу, ёс бус зан чанараа хаяж чадна. Үүний тулд юуны түрүүнд энэ өргөст болон хогийн ургамал миний сэтгэлийг хичнээн өвтгөж, бохирдуулж байгааг ухаарах хэрэгтэй.

Сайн хөрс

“Зарим нь сайн хөрсөнд унаж ургаад, ургацаа өгөхөд зарим нь зуу, зарим нь жар, гуч дахин их болов” (Матай 13:8).

Сайн хөрс бол замын хавийн хөрс шиг хатуу биш зөөлөн хөрс юм. Ийм сайн хөрсөнд үр таривал хөрс нь зөөлөн тул хурдан үндэслэж бат бэх болдог. Мөн тэр хөрс нь чийг, болон эрдэс бодисоор баялаг тул маш амархан соёолж ургалт түргэсдэг. Энэ мэт сайн хөрс мэт сэтгэл нь Бурханы үгийг сонсон, сайн хүлээж авдагба түүнийхээ дагуу үйлддэг.

Түүнчлэн ийм хөрсөнд чулуу байдаггүй тул Бурханы үг хурдан үндэслэж бат бэх болдог. Ямар нэгэн сорилт хавчлага ирсэн ч Бурханы үгэнд л дуулгавартай байж чаддаг сэтгэл юм. Тэнгэрийн орны хамгийн үзэсгэлэнтэй газар Шинэ Иерусалимд оруулахыг хүсэж буй Бурханы сэтгэлийг ухаарч мэдэрдэг тул баяртайгаар үг сургаалийн дагуу үйлдэн амьдардаг

тул (Лук 8:8) амьдралдаа ивээл, ерөөл арвин их үр жимс дүүрэн байдаг.

Ийм цайлган сайхан сэтгэлийг бий болговол тэвчээр хэрэгтэй байдаг. Сүнсээр үнэнээр мөргөлдөө оролцож, гал мэт халуун залбирч, сургаалийн дагуу сахин үйлдэх тусам асар хурдан сайн хөрс мэт сэтгэлийг бий болгож, сүнс махан талын арвин их үр жимсээр Бурхандаа алдарыг өргөх болно.

“Эдгэрэх ямар ч найдлаггүй байсан намайг Бурхан дахин амьдруулсан юм”

Чей Хе мин сүмд үйлчлэгч
(Нью Йорк Олон улсын манмин сүм, Америк)



Чей Хе мин сүмд үйлчлэгч том охин Сони, бага охин Хани нар.

2005 онд манай гэр бүл Америкийн нэгдсэн улсын Нью-Йоркт шилжин суух амьдрах болсон. Бид И Жей руг тэргүүн пасторын 2006 оны долдугаар сард Нью-Йоркт Мадисон цэцэрлэгийн талбайд хийсэн нэгдсэн цуглаанд оролцсон юм. 3 өдрийн турш гэмшил, эдгэрэл, тэмдэг

гайхамшигуудаар дүүрэн эрх мэдэлт хүчний үйлсийг нүдээр үзэж мэдрсэн юм. Энэ үед би Ариун Сүнсээр дүүрч, итгэлээр ч өссөн юм. Гэвч үүний дараа цаг хугацаа өнгөрөх тусам залбирал хийх хэвшил алдагдаж, энэ дэлхийн зүйлстэй хутгалдсан юм.

Олон удаагийн хагалгаа, бас хэт их цус алдсанаас болж дахин амьдрах боломжгүй мэт надад санагдаж байлаа

2012 оны эхээр би хоёр дахь хүүхдээ 12 жилийн дараа гаргасан. Жирэмсэн байхдаа савны хоргүй хавдраас болоод дөрвөн сар хүртлээ би их хэмжээний цус алддаг байсан. Тэгээд л байн байн эмнэлэгийн яаралтай тусламжийн өрөөнд ордог байлаа.

И Жей руг тэргүүн пасторын өвчин эдгээх залбирлыг интернетээр авч мөн Тэргүүн Пасторын залбирч өгсөн гар алчуурын (Үйлс 19:11-12) залбирлыг ч авсан. Түүнээс хойш тун ч удалгүй миний цус алдалт зогсож, ямар ч өвчин хөндүүр зовиургүйгээр жирэмсний 10 дах сараа хүргэсэн.

Анхныхаа хүүхдийг хийсвэр хагалгаа хийлгэж гаргасан учраас 2012-11 сарын бнд өглөөний 11 цагийн үед би хоёр дахь хүүхдээ ч мөн хийсвэр хагалгаагаар төрүүлсэн. Хагалгаа ердийн үеийнхээс 2 цаг гаруй хугацаагаар илүү үргэлжилсэн болохоор би ухаан алдсан байсан.

Төрөлтийн дараа үтрээнээс гардаг шавхарганаас болж ингэж их хэмжээний цус алдсан. Анхны хүүхдээ төрүүлсэний дараа ийм юм тохиолдоогүй зүв зүгээр байсан ба саванд наалдац үүсэж, давсаг идээлсэн байсан. Цаашлаад эхэс, сав, давсаг хоорондоо наалдаад эхэс гарч өгөхгүй байсан. Ийм хэцүү байдалтай байсан ч манай эмч нар эхэсийг салгаж авсан.

Гэвч савны агшилт маш муу байснаас их хэмжээний цус алдахад хүрсэн. Би 9 удаагийн цус сэлбэлт хийлгэж, эмч нар савны дотор талын арьсан доорх бөмбөлөгийг шахаж цус алдалтыг зогсоохыг хичээж байсан ч ер нэмэр болоогүй.

Энэ өдөр орой 9 цаг гэхэд байдал яг л адилхан байсан бөгөөд элэгний артерийн судасыг холбон боолт тавьсан ч бас ямарч үр дүнгүй байлаа. Эцэст нь савыг тайрч авах шаардлагатай болж миний савыг гаргалаа.

Эмч нар савыг гарган аваад давсаганд наалдсан хэсгийг маш болгоомжтойгоор салгаж, давсагны гэмтсэн хэсгийг зассан ч энэ бүгд ямар ч үр дүнгүй л байлаа. Би цус алдсаар л байсан болохоор гэдэс маань бүр хавдсан байсан. Эцсийн дүнд хэвлийг зүсэх яаралтай хагалгаанд орох шаардлагатай болж, хэвлийн хөндийн ханыг тэр чигээр нь зүсэх мэс засалд орлоо. Эмч нар гэдсийг нээж, цусыг юүлэн авч, давсагны арын хэсэгт олдсон хэдэн нүхийг битүүлж эмчилсэн. Гэвч мөн л цус алдсаар л байлаа.

И Жей руг тэргүүн пасторын цаг хугацааг алгассан залбирлаар би дахин амьдарсан

Нью-Йорк олон улсын манмин сүмийн Шим Жеймс пастор, болон түүний эхнэр миний төлөө мацаг барин залбирч байлаа. Солонгост байдаг манай гэр бүлийнхэн ахан дүүс маань ч миний гэр бүлийн өмнөөс

гэмшин залбирч, манай гэр бүлийнхэн ялангуяа би өөрөө ч итгэлийн амьдралаар амьдарч чадаагүйн төлөө бас мацаг барин залбирч байсан юм.

Бурханы ивээлээр, Тэргүүн Пастор миний талаар сонсонгуугаа уулан дахь залбирлын өргөөндөө залбирч байсан гэсэн. Тэргүүн Пастор маань чин сэтгэлээсээ Бурханы хүчээр цаг хугацаа алгассан залбирал хийж өгсөн гэж би сонссон. Түүнийг миний төлөө залбирсан яг тэр мөчид цус алдалт зогссоныг би мэдсэн. Энэ нь үхээд дөрвөн өдөр босон Лазар Есүсийн хүчээр дахин амилсан шиг тийм л хүч байсан юм. Халеллуяа!

Би маш хурдан эдгэрч, хоёрхон өдрийн дараа эрчимт эмчилгээний тасгаас ердийн тасаг руу шилжсэн. Эмч нар энэ бол үнэхээр гайхамшиг байсан, миний дахин амьдрах болсон нь жинхэнэ гайхамшиг бас ийм хурдан эдгэрч байгаа нь хүртэл гайхамшиг гэж хэлж байсан юм. Энэ бол жинхэнэ Бурханы л хүч чадлаар хийгдсэн ажил гэж ярилцаж байсан бөгөөд миний тухай тэр эмнэлэгт ярианых нь гол сэдэв болж байлаа.

2012 оны 11 сарын 27нд эмнэлэгээс гарсанаас хойш миний бие маш хурдан сайжирсан. Үүнээс хойш би маш их гэмшсэн ба Бурханд итгэдэг гэсэн мөртлөө жинхэнэ итгэл байгаагүй, хэдийгээр олон удаа би өөрөө гэрчилж байсан ч Тэргүүн Пастороор дамжуулан хийж байгаа Бурханы хүчинд бүрэн итгэдэггүй байсан юм.

Мөн Бурхантай хамааралгүйгээр энэ дэлхийн амьдрал хичнээн хоосон хоосны хоосон болохыг чин сэтгэлээсээ ухаарсан төдийгүй бүдэг бадаг бодож байсан Шинэ Иерусалимд илүү их хүсэн тэмүүлэх болсон юм.

Үхэхээс өөр аргагүй байсан намайг дахин амьдруулсан Бурхандаа бүх алдар, магтаал талархалыг өргөж байна.

“Миний амьдралыг өөрчилсөн ариун сургаал”



Донни Еи итгэгч (зүүн талаас хоёр дахь) болон түүний гэр бүл. (Шибү Зүүн Малайз)

2010 оны 11-р сард ноён Давид Лу надад Манмин мэдээ сонинг өгсөн юм. Түүн дээр Бурханы хүч чадал агуулагдсан гэрчлэлүүдийг би үнэхээр гайхсан ба И Жей руг тэргүүн пасторын сургаалиар дамжуулан сэтгэл их хөдлөж, ивээл их авсан юм. Учир нь урьд нь би Библи уншаад ойлгодоггүй зарим нэг ишлэлээс болж хааяа сэтгэл хоосон санагддаг байсан ч Манмин мэдээ сонин дээр гарсан сургаал нь ойлгоход маш амархан мөн ивээлтэй байсан учраас юм.

Энэ мэт Бурханы үг миний сэтгэлд орж эхэлсэнээс миний амьдрал маань өөрчлөгдөж, байсан эхнэр бид хоёр бие биеэ ойлгоцохгүй, үргэлж л зөрчилддөг байсан бол харин одоо үнэхээрийн амар тайван гэр бүл болж чадсан билээ.

Мөн Давид Лу захирлаар дамжуулан Малайзын Манмин хэвлэх үйлдвэрийн захирал Жон Дебора Тангтай танилцсаны дараа Бурханы хүсэл улам ихээр ухаарсан юм. Ялангуяа хиймэл

шүтээний талаар сонсон тийм зүйл шүтэж байсандаа гэмшиж, гэртээ байх лууны дүртэй зүйл болон хиймэл шүтээнүүдээ хаяж, устгасан юм. Үүний дараа манай гэр бүл хүнд ачаанаас чөлөөлөгдсөн мэт эрх чөлөөг мэдэрч, жинхэнэ аз жаргал, баяр баясгалан манай гэр бүлд ирсэн юм.

Бас нэг талархалтай зүйл бол GCN (Жи Си Эн) телевизийн хөтөлбөрүүдийг үзэж, болон Тэргүүн пасторын “*Ухлийн өмнөх мөнх амийг амссан нь*”, “*Там*” гэх мэт номуудыг уншсанаар миний итгэлийн амьдрал болон сүнсний өсөлтөнд их тус дэм болсон. 2011 оны 4-р сарын 1нд Манмин Мөв Сүмд интернетээр бүртгүүлж, 2012 оны Манмин Төв Сүмийн зуны цуглаанд Солонгост очиж оролцсон.

Би одоо Малайздаа Манмины үйлчлэл, ариун сайн мэдээг тараах ажлыг зохион байгуулахыг хүсэж байгаа ба мөн Тэргүүн пасторын ном болон Манмин сонин, ариун сургаалыг чин халуун сэтгэлээр тараах ажилтан болохыг хүсэж байна.

Улаанбаатар Манмин Сүм

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10: 30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11: 30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18: 00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21: 30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09: 00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15: 00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17: 00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 12-р хороо, Хангайн 3-57 тоот Улаанбаатар Ариун баярт мэдээ чуулган
Чуулганы утас: 976-11-351437
Чуулганы хариуцсан төлөөлөгч: Г. Анхбаяр СМТ 976-91173712 976-91615337
E- шуудан : power3712@gmail.com

Mongolian

Манмин Мэдээ

Published by Манмин Төв Сүм

235-3 Гуро-Здонг, Гуро-гу, Сеул,
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-2818-7048
http://www.manmin.org/english
e-mail: manminministry@hotmail.com
Нийтлүүлэгч: Жаерок Лее
Редактор: Геумсун Вин